**ЯРИЛЦЛАГА, НИЙТЛЭЛ** · 2021 оны 2-р сарын 19

# Ц.НАСАНБАТ: С.БАТБОЛД НАРЫН ХӨРӨНГИЙГ ЦАРЦААХ, БИТҮҮМЖЛЭХ АЖИЛЛАГАА ГАДНЫН ЗУРГААН ОРНЫ ШҮҮХЭД ЗЭРЭГ ЯВАГДАЖ БАЙГАА




Ерөнхий сайд асан /2009-2012/, УИХ-ын гишүүн С.Батболдтой холбоотой дуулиан олон нийтийн сүлжээ, зарим мэдээллийн хэрэгслээр эрчимтэй гарах болсон. Тухайлбал: Нью-Иоркийн шүүхэд нэхэмжлэл гаргасан иргэд түүнийгээ буцаан татсан, оффшор бүс дэх хөрөнгөө байршуулсан нь ил болсон гэх мэдээллүүд цацагдсаар буй. Харин УИХ-ын гишүүн С.Батболдын зүгээс энэ бүхнийг "гүтгэлэг" хэмээн мэдэгдэж, мэдэгдэл хүртэл гаргасан. Тиймээс ч хууль хяналтын байгууллагууд эл асуултад яг ямар хариу өгөх нь ихээхэн анхаарал татаж буй. Уг асуудлаар Нийслэлийн прокурорын газрын орлогч прокурор Ц.Насанбаттай ярилцлаа.

С.БАТБОЛДЫГ ЯЛЛАГДАГЧААР ТАТААГҮЙ НЬ ҮНЭН, ГЭХДЭЭ ОФФШОРЫН АСУУДАЛ НЬ ТУСДАА

***УИХ-ын гишүүн С.Батболдыг оффшор бүсэд данс, хөрөнгөтэй гэх мэдээлэл***

***сүүлийн үед нэлээд цацагдсан ч үүнийг үгүйсгэж байгаа. Үнэхээр УИХ-ын гишүүн оффшорт хөрөнгөө нуусан байвал эрүүгийн хэрэг үүсгэж шалгуулах ёстой. Та өнгөрсөн сард мэдээлэл өгөхдөө “УИХ-ын гишүүн С.Батболдтой холбоотой эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татсан болон мөрдөн байцаалтын явуулж буй хэрэг байхгүй” гэж байсан. Олон нийтэд эргэлзээ, ойлголтын зөрүү үүсгээд буй энэ асуудлын талаар яг тодорхой мэдээлэл өгнө үү.***

Улсын Ерөнхий прокурорын газраас 2020 оны хяналтын ажлын нэгдсэн дүн мэдээ болон Нийслэлийн прокурорын газраас хяналт тавьсан, олны анхаарал татсан эрүүгийн хэргүүдийн явц, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг прокурорын байгууллага ээлжит хэвлэлийн бага хурлаараа олон нийтэд өгсөн. Тухайн үед сэтгүүлчдийн урьдчилж бичгээр ирүүлсэн болон цахимаар шууд тавьсан асуултуудын дотор, УИХ-ын гишүүн С.Батболдод эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татан мөрдөн байцаалт явуулж буй эрүүгийн хэрэг байхгүй боловч нийтийн албан тушаалтнуудтай холбоотой оффшор бүсэд компани эзэмшдэг, хууль бус орлогоо нуусан эсэх талаарх мэдээллийн дагуу мөрдөн шалгах ажиллагаа явагдаж буйг тодорхой хэлсэн шүү дээ.

Панамын баримт бичиг гэсэн нэрээр нь нийтээр мэддэг эдгээр асуудлаар Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц болон Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хэргийг мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байгааг ч дурдсан. Ийм төрлийн хэргийг шалгахад хамрах хүрээ нь зөвхөн Монгол улсын нутаг дэвсгэр дэх асуудал биш учраас гадаад орнуудтай мэдээлэл, нотлох баримт солилцох, баримтат мэдээллийн эх сурвалжийг олж тогтоох зэрэгт маш их цаг хугацаа шаардагддаг юм. Жишээлбэл: Ийм төрлийн хэргийг шалгахад Авлигатай тэмцэх газраас гадаад орнуудын ижил эрх бүхий мөрдөх байгууллага, мөн бүс нутгийн болон, олон улсын байгууллагатай харилцан мэдээлэл солилцож, үүнд тулгуурлан нотлох баримт солилцох хэлбэрээр маш өргөн хүрээнд хамтран ажиллаж, цаг хугацаа, хөдөлмөр зарцуулж байж үр дүн, ахиц гаргадаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Эрүүгийн хэрэгт шаардлагатай нотлох баримтыг гадаадаас авахаар мөрдөгчийн даалгавар хүсэлт бичдэг юм. Нийслэлийн прокурорын газраас зөвхөн 2020 онд мөрдөгчийн даалгавар, хүсэлт 24-ийг гадаад улсад хүргүүлсэн байна. .

***УИХ-ын гишүүн С.Батболдын ажлын албанаас энэ оны 1 дүгээр сард мэдэгдэл гаргасан байсан. Түүнд “С.Батболдод холбогдуулан улс төрийн нэр хүндийг нь харлуулах зорилготой зохиомол хэрэг үүсгэж, гүжир гүтгэлэг тарааж байгаа, энэхүү гүтгэлгийг тарааж буй этгээд үнэнд гүйцэгдэн Нью-Йоркийн шүүхэд гаргасан нэхэмжлэлээс С.Батболдын нэрийг өөрсдөө татан авсан болно. "Эрдэнэт" УБҮ, "Эрдэнэс Оюу Толгой" ХХК зэрэг хуулийн этгээд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, тэр бүү хэл Монгол Улсын Засгийн газрын нэрийг гадаадын шүүхэд хуурамчаар ашиглан маргаан, нэхэмжлэл гаргасан мэтээр эхлүүлсэн...” гэсэн. Хууль хяналтын байгууллагынхан яагаад энэ талаар тодорхой ойлгомжтой мэдээллийг олон нийтэд хандаж өгөхгүй байгаа юм бэ?***

Дээрх мэдэгдэл нь УИХ-ын гишүүн С.Батболд нарт холбогдуулан Нийслэлийн Прокурорын газраас 2020 оны 10 дугаар сард Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Эрдэнэс оюу толгой” ХХК-аар дамжин ашигт малтмалын орд газрууд дахь нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, түүнийг хамгаалах зорилготой бичсэн нэхэмжлэлтэй холбоотой илэрхийлсэн байр суурь гэж ойлгож байна.

Прокурорын байгууллага нь төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх үүднээс иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх хуулиар олгогдсон. Энэ нь Монгол улсын Үндсэн хууль дахь “Прокурор шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох” гэсэн үндсэн суурь зохицуулалт, Прокурорын тухай хуулийн 20, 21 дүгээр зүйлд заасан “төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл ...өөрийн санаачилгаар иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох” эрхээр тодорхойлогдож байдаг. Үүнийг эрх гэхээс илүү Прокурорын байгууллагын үүрэг гэж ойлгож болно. Товчхондоо, хамгийн энгийн байдлаар жишээ авч тайлбарлах замаар таны асуултад хариулахыг хичээе.

Ер нь төр, нийтийн ашиг сонирхол гэж юу юм бэ? та бүхэн асуух, эсхүл бодох байх. Жишээлбэл, Улаанбаатараас ч юм уу аль нэг газраас, хэн нэгэн Сэлэнгэ аймгийн аль нэг суманд очоод, хууль бусаар ашигт малтмал олборлон, газар сэндийлж, байгаль экологид хохирол учруулчхаад явчихвал хэн тэр этгээдийг олж, байгаль орчныг нөхөн сэргээлгэх, эсхүл нөхөн сэргээх зардлыг тэр хүнээс шаардах вэ? Гэр бүлийн хүчирхийллийн улмаас насанд хүрээгүй хүүхдийн эрх зөрчигдсөн байвал хэн энэ асуудалд анхаарал хандуулах ёстой вэ?, Тодорхой албан тушаалтны хууль бус, буруу үйл ажиллагаанаас улсын төсөвт хохирол учирсан бол түүнийг төлүүлэхээр шүүхийн журмаар хэн хэрхэн шаардах вэ?, Байгалийн баялгийг өмчлөх, захиран зарцуулах Төрийн онцгой эрхийг ноцтой зөрчсөн, тодорхой хүн, эсхүл гадаад, дотоодын аль нэг компани хэт ашиг олсон хэлцэл хийх замаар олборлосон байгалийн баялгийг зарсан, хууль бусаар хөрөнгөжсөн бол хэн үүнийг шүүхийн журмаар шаардаж, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх юм бэ?  Өөрөөр хэлбэл, хүний эрх, тэр дундаа хүүхдийн эрх, хүрээлэн буй орчны асуудал, төсөв, төрийн өмч, байгалийн баялгийг өмчлөх, эзэмших, захиран зарцуулахтай холбоотой эрх ашиг зөрчигдөж байна уу, түүнийг хэрхэн хамгаалах, зөрчигдсөн бол хэрхэн сэргээх вэ гэдэг асуудал юм л даа. Үүнийг л хийж хэрэгжүүл гэж прокурорын байгууллагад хуулиар эрх олгосон бөгөөд цаад утгаараа энэ нь хэрэгжүүлэх ёстой үүрэг байдаг.

**Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор ямар бодит ажил хийв?**

2020 оны жилийн эцсийн мэдээгээр төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор Нийслэлийн прокурорын газраас иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангасан мөнгөн дүн 417 тэрбум төгрөг болж байна. Говь-Алтай аймагтай ойролцоо зургаан аймгийн жилийн төсөв гэсэн үг.

Капитал банктай холбоотой хэрэгт Авлигатай тэмцэх газар, Эрүүгийн цагдаагийн албан хамтарсан ажлын хэсэг мөрдөн байцаалт явуулж,  Нийслэлийн прокурорын газраас хянаж байгааг та бүхэн мэднэ. Энэ хэргийн мөрдөн байцаалтын явцад

Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын сангийн 240 тэрбум төгрөгийг хэвийн үйл ажиллагаа нь алдагдаж байсан Капитал банканд байршуулах шийдвэр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс гаргасан. Улмаар төр мөнгөө авч чадахгүй болчихсон нөхцөл байдал нотлогдсон. Өөрөөр хэлбэл, хөгшчүүлийн тэтгэвэрт зарцуулагдах, эмнэлэгт хэвтэж байгаа өвчтөнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зардлын эх үүсвэр 240 тэрбум төгрөгөөр дутсан, эдгээр сангууд эх үүсвэрийн хомстолд орсон байна. Энэ нь төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн нөхцөл байдал учраас прокурор одоо яах, юу хийх ёстой вэ гэсэн асуудал бий болж байгаа биз. Капитал банк нэгэнт татан буугдсан учраас, Нийслэлийн прокурорын газраас Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хамтран дээрх мөнгийг тухайн банк дахь Эрх хүлээн авагчаас гаргуулахаар нэхэмжлэл гаргаж, одоо шүүхийн шийдвэр гарч, хүчин төгөлдөр болсон.

**Шүүхийн шийдвэр гарсан ч дампуурсан банкнаас юу авах юм бэ гэж иргэд дүгнэн, олон нийтийн сүлжээнд уг мөнгийг гаргуулах талаар давлагаа үүсгэе гээд байдаг шүү дээ.**

Мэдээж, ийм асуудал гарна л даа. Тэгэхээр мөрдөх болон прокурорын байгууллага үүнээс урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авсан бэ гэдэг талаар мэдээлэл эхлээд өгье. Хэрэг нээсэн даруйд Капитал банкны хөдлөх болон үл хөдлөх хөрөнгүүдийг битүүмжилж, шилжилт хөдөлгөөнийг нь прокурорын шийдвэрээр хязгаарлачхаад байгаа. Багагүй хөрөнгө хамгаалах арга хэмжээ авсны үр дүнд одоо хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр Капитал банкны эрх хүлээн авагчаас гаргуулах 240 тэрбум төгрөгөөс дийлэнхийг эдгээр битүүмжилж, хамгаалсан хөрөнгөөс гаргуулах бодит боломж бүрдэх нөхцөл бий болсон юм. Төр нийтийн эрх ашгийг хамгаалах гэдэг чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлж байгаагийн бодит, дотоодод байгаа жишээн дээр хэлэхэд ийм байна.

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ЗҮГЭЭС С.БАТБОЛД НАРЫГ ГҮТГЭЖ, ГҮЖИРДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ

**Тэгвэл УИХ-ын гишүүн С.Батболдод хамаарах кэйс нь төр нийтийн эрх ашиг дотоод, гадаадыг дамнасан үйлдлийн улмаас зөрчигдсөн тохиолдол мөн үү?**

Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд прокурорын байгууллагаас УИХ-ын гишүүн С.Батболд нарын нийт 14 хариуцагчид холбогдуулан **нэгдүгээрт**, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ аас зэс, молибдений баяжмалыг худалдаалах хууль зөрчсөн гэрээнүүдийг байгуулах эрх олгож, хуулиар хориглосон нуугдмал ашиг олсон, **хоёрдугаарт,** “Оюу Толгой” ХХК-ийн өмчлөл, менежменттэй холбоотой асуудлаар бусдад давуу байдал олгож, ийнхүү өмчлөх эрх, татвар ногдуулалт, хөрөнгө оруулалтын таатай нөхцөл горимыг бүрдүүлэн өгснийхөө хариуд “Туркойз Хилл Ресурс Лимитед” буюу хуучнаар “Айвенхоу майнз лимитед компанитай холбоо бүхий хувь этгээд, компаниудаас хуулиар хориглосон мөнгөн төлбөр авч, ашиг хонжоо хүртсэн гэх үндэслэлтэй нэхэмжлэлийг гаргаж, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна. Энэ иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох баримт сэлтүүдийн дотор төрийн нууцад хамаарах мэдээ байгаа, эсэхийг шалгуулах хүсэлтийг УИХ-ын гишүүн С.Батболдын итгэмжлэгдсэн

төлөөлөгч шүүхэд гаргасныг мэргэжлийн байгууллагын шинжээчид нягталж, нэхэмжлэлд төрийн нууцад хамаарах мэдээ баримт агуулагдаагүй гэсэн дүгнэлтийг хэдхэн хоногийн өмнө гаргасан. Өөрөөр хэлбэл, саяхныг хүртэлх хугацаанд уг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар олон нийтэд хандан прокуророос тодорхой мэдээлэл хийгээгүй нь шинжээчийн дүгнэлт хэрхэн гарахаас хамаарч, хүлээцтэй, хүндэтгэлтэй хандаж, хууль ёсны байх зарчмыг баримталж ирсэнтэй холбоотой. Нөгөөтээгүүр хэд хэдэн улс орны шүүхэд одоо нэгэнт явагдаж байгаа маргааны талууд шүүхийн танхимд бус, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр харилцан мэтгэлцэх нь угтаа зохимжгүй.

Прокурорын байгууллагын хувьд хариуцагч, УИХ-ын гишүүн С.Батболд, түүний хүү, бусад хүн, хуулийн этгээдийн нэр төр, эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдаж хязгаарласан шинжтэй, үндэслэлгүйгээр гүжирдэн гүтгэсэн ямар нэгэн үйл ажиллагаа огт явуулаагүй. Одоогоор УИХ-ын гишүүн С.Батболд, түүний төлөөний этгээд байж болзошгүй хүн, хуулийн этгээдэд холбогдох эрх сэргээх нэхэмжлэл, гадаад улс дахь өмч хөрөнгийг далдлах, бусдад аливаа хэлбэрээр шилжүүлэхээс сэргийлэх зорилго бүхий хөрөнгө битүүмжлэх, царцаах ажиллагаа, холбогдох нотлох баримт шүүхийн журмаар гаргуулах иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанууд Англи-Уэльс, Хонконг, Сингапур, Жерсий, АНУ, Их Британийн Виржинийн Арлууд гэсэн зургаан орны шүүхэд зэрэг явагдаж байгаа.

**Яагаад иргэний хэрэг үүсгэх журмаар ийм ажиллагаа явуулж байгаа вэ гэдгийг тодотгохгүй юу?**

Нэгдүгээрт, АТГ-аас гадаадын байгууллагуудтай хамтран шалгаж нотолсон үйл баримтаар УИХ-ын гишүүн С.Батболд болон түүний хамаарал бүхий хүн, хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй компани, хөрөнгүүд нь Монгол Улсын хувьд Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй улсууд, мөн нийтийн ярьдгаар зарим хөрөнгө нь оффшор гэх тодотголтой бүсүүдэд байсан. Хоёрдугаарт, гадаад орнуудад хууль бус арга хэрэгслээр олсон байж болох хөрөнгийг битүүмжлэх, хамгаалах буюу нийтийн эрх зүйн хэллэгээр хөрөнгө царцаах, буцаах гэдэг ажиллагаа нь Иргэний шүүхийн журмаар шийдвэрлэгддэг тул нэгэнт гадаад орнууд дахь эд хөрөнгийн эрхийн асуудлыг тухайн улсуудын хууль журмаар шийдвэрлэх хэрэгцээ бий болсон. Тиймээс тухайн орнуудын хуульчидтай хамтран ажиллаж байгаа юм. Энэ бүх иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд УИХ-ын гишүүн С.Батболд нь прокурорын байгууллагатай ижил тэгш эрх эдлэн оролцож, дэлхийн дахинд хүлээн зөвшөөрөгдсөн, шилдэг сайн хуулийн фирмээр эрх ашгаа хамгаалуулж байна. Өөрөөр хэлбэл, УИХ-ын гишүүн С.Батболд өөрийг нь, гэр бүлийн гишүүд, бизнесийн түншүүдийг нь гадаад улсын шүүхүүдэд баримт нотолгоогүйгээр гүжирдэн гүтгэсэн гэж үзэж байгаа бол түүнийгээ нотолж, өөрийнхөө эрх ашгийг хамгаалах бүхий л эрх, хууль зүйн боломж нь дотоодод ч, гадаадад ч бүрэн хангагдсан.

АНГЛИ, ХОНКОНГ, СИНГАПУР, ЖЕРСИ ДЭХ ХӨРӨНГҮҮДИЙГ НЬ БИТҮҮМЖЛЭХ ШИЙДВЭРҮҮД ГАРСАН

**Гадаад улсад С.Батболд гишүүнтэй холбоотой хөрөнгийг битүүмжилсэн гэсэн үг үү. Энэ талаар үнэн, худал гэсэн мэдээлэл их цацагдаж байгаа. Нью-**

**Йоркийн шүүхэд гаргасан нэхэмжлэлээс татгалзсан гэсэн асуудал ч яригдаад байгаа шүү дээ.**

Прокурорын байгууллагаас УИХ-ын гишүүн С.Батболд нарын 14 хариуцагчид холбогдуулан нэхэмжлэл гаргаж, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд иргэний хэрэг үүсгэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа талаар түрүүн хэлсэн. Тус шүүхэд иргэний хэрэг үүсгэсэн захирамж гарсантай холбоотойгоор энэ мэдээллүүдээ хамтарч байгаа гадаадын хуульчдад хүргүүлж, хэвлэлээр дурдагдаад байгаа АНУ-ын Нью-Йорк мужийн Дээд шүүх болон бусад таван орон, нийт зургаан улсад хөрөнгө хамгаалах, хөрөнгө буцаахтай холбоотой иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэн. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын “Хөрөнгө буцааж олгох арга хэмжээ” гэсэн хэсгийн 53 дугаар зүйлд “Оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан байж болох эд хөрөнгийг өмчлөх эрх буюу өмчлөлийг тогтоох зорилгоор өөрийн шүүхэд иргэний хэрэг үүсгэхийг зөвшөөрөх, шаардлагатай байж болох бүхий л арга хэмжээ”-г хохирогч улсын өмнө хүлээх агуулгыг тодорхойлсон байдаг. Конвенцын энэ заалтын дагуу хөрөнгө байршиж байгаа улсууд болох **Англид 20 сая, Хонконгод 30 сая, Сингапурт нэг сая, Жерсид 16 сая ам.долларын үнийн дүн бүхий хөрөнгө, эрхийг битүүмжлэх, царцаах захирамж тухайн улс орны шүүхээс гаргасан** талаар хамтран ажиллаж буй хуульчид мэдээлэл ирүүлсэн. Энэ талаар цахим хуудсуудад ч мэдээлэл нь гарсныг хэн ч харах боломжтой. Жерси гэдэг Үндсэн хуульт хаант засаглалтай, Европ тив дэх арлын улс болох нь харагдана. Нью-Йорк мужийн Дээд шүүх (мужийн шүүх)-ийн хувьд нэхэмжлэгч талаас битүүмжлэх шаардлагатай гэж үзсэн хөрөнгүүдийг эзэмшигч, хариуцагчаар татагдсан этгээдүүд нь бусдад шилжүүлэхгүй, захиран зарцуулахгүй байх, шилжүүлэх тохиолдолд 60 хоногийн өмнө урьдчилж мэдэгдэх баталгааг шүүхэд гаргаж өгсөн. Одоо АНУ-ын “JPMorgan Chase NA” банкнаас шүүхийн журмаар нотлох баримтууд гаргуулах ажиллагаа АНУ-ын Нью-Йоркийн Өмнөд дүүргийн шүүх (Холбооны улсын шүүх)-д тус тус явагдаж байна.

**Процессын хувьд нэлээд их цаг хугацаа зарцуулахаар байгаа юу?**

Хөрөнгө битүүмжлэх ажиллагаа, тэр дундаа гадаадын оффшор гэгдэх бүсүүд дэх хөрөнгийг царцаах асуудал нь туйлын амаргүй ажил. Оффшор бүсүүдэд байрлаж буй эдийн болон эдийн бус баялаг, хөрөнгийг гэнэт хөдөлгөн шилжүүлэх, дахин эргэлтэд оруулан далдлах эрсдэл зэргээс сэргийлэхийн тулд маш олон хүчин зүйлийг тооцож, тухайн улсын материаллаг болон процессын хууль тогтоомжийг харьцуулан судлах шаардлагатай бөгөөд хамгийн чухал нь энэ бүх ажиллагааг олон улсын мэргэжлийн оролцогч нарын туслалцаа, хамтын ажиллагаанд тулгуурлан явуулдаг онцлогтой. Монгол Улсын хуулийн “гар” төдийлөн хүрч чаддаггүй байсан оффшор бүс дэх нуугдмал хөрөнгийг илрүүлж, буцаан авчрах чиглэлд томоохон дэвшил, туршлага энэ хүрээнд бий болж байна.

Гадаад улсын дээрх шүүхүүдэд гаргаж буй хөрөнгө битүүмжлэх хүсэлтийн үндэслэл, баримтыг тухайн орны шүүгч нар нарийвчлан нягтлан үзэж, зөвхөн шаардлагатай тохиолдолд тэр төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Хэрэв шүүхэд худал, үндэслэлгүй, хуурамч нотлох баримт гаргаж өгсөн тохиолдолд, шүүхийг үл хүндэтгэж

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан гэмт хэрэгт буруутгах шууд үр дагавар бий болдог нь манай улсын хуультай ижил харагдаж байна. УИХ-ын гишүүн С.Батболд хэдийгээр өөрийгөө болон хамаарал бүхий этгээдүүдээ үндэслэлгүйгээр гүтгүүлсэн гэж тайлбарлаж буй боловч гадаад улсын шүүхүүдэд ил болсон эдгээр үйл баримтуудад өөрийгөө хамааралгүй болохыг нотолсон тайлбар гаргаж өгсөн, эсэх талаарх баримт мөн тухайн цахим хуудсанд өнөөдрийг хүртэл харагддаггүй .

**Эдгээр үйл баримт гэдгээ тодотгож, заримаас нь дурдаж болох уу?**

АНУ-ын шүүхийн цахим хуудсанд ил байршуулсан мэдээллүүдэд УИХ-ын гишүүн С.Батболд нуугдмал хөрөнгө эзэмшиж байж болзошгүйтэй холбоотой олон баримтат зүйл байгаагаас зөвхөн энэ хүрээнд дөрвөн зүйлийг дурдъя. Яагаад дурдаж буй шалтгаанаа дахин сануулах нь зүйтэй байх. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь талуудын харилцан эрх тэгш байх зарчимд суурилдаг шүү дээ. Хариуцагч талд ч, нэхэмжлэгчид ч, олон нийтэд ч нэгэнт нээлттэй байгаа ил мэдээлэл учраас зөвхөн тэр мэдээллийн хүрээнд, зарим баримтыг эш татаж, дэлгэрүүлэн тайлбарлаж байгаа юм. Ингэснээр нийтэд түгээд буй Нью-Йорк дахь нэхэмжлэлийг хэн татчихав, яагаад татчихав, татсан этгээд нь буруутай юу гэх мэтээр ярьж байгаа ташаа ойлголтод хариулт өгөх болов уу.

**Нэгдүгээрт,** Британийн Виржинийн арлуудын шүүхээр дамжуулан нотлох баримт гаргуулан авахад, “Премиер эдж лимитед” гэсэн нэртэй, тус арлуудад бүртгэлтэй компанийг анх 2005 оны наймдугаар сарын 15-нд үүсгэн байгуулах үеэс 2006 оны дөрөвдүгээр сарын 25-ныг хүртэл хугацаанд тус компанийн хувьцааг УИХ-ын гишүүн С.Батболд дангаар эзэмшиж байсан талаарх баримт байна. Энэ нь С.Батболд Монгол Улсын Үйлдвэр, худалдааны сайдаар ажиллаж байх хугацаатай давхацдаг. Энэ хугацаанд уг оффшор компани 2006 оны хоёрдугаар сарын 23 болон гуравдугаар сарын 8-нд Лондон хот дахь “Knightsbridge apartment” хэмээх үнэ цэнтэй хоёр сууцаас худалдан авсан. Үүний зэрэгцээ С.Батболд гишүүн 2006 оны гуравдугаар сард “Квантум лэйк траст” (Quantum Lake Trust) хэмээх нэртэй оффшор дахь хөрөнгө итгэмжлэх нэгж бүтцийг үүсгэн байгуулж байсан нь баримтаар нотлогдоод байна. 2006 оны дөрөвдүгээр сард буюу Монгол Улсад Авлигын эсрэг хууль батлагдахаас гурван сарын өмнө, С.Батболд гишүүн “Премиер эдж лимитед” оффшор компанид өөрийн эзэмшдэг хувьцаагаа “Регула лимитед” хэмээх Британийн Виржинийн арлуудын өөр нэгэн компанид шилжүүлсэн. 2015 оны зургадугаар сарын 11-нд “Премиер эдж лимитед” компанийн хувьцаа энэхүү “Регула лимитед” гэх компаниас С.Батболд гишүүний хүү Б.Баттүшигт шилжсэн. Үүнээс хэдэн сарын дараа мөн хүүхдүүд нь болох Б. Баттүшиг, Б.Самаади нар хувьцаа эзэмшигч болж бүртгүүлсэн. “Премиер эдж лимитед” компанийн бүртгэлтэй төлөөлөгч этгээд, “Квантум лэйк траст”-ын менежер нарын хоорондын 2015 оны долдугаар сарын цахим шууданд, “Премиер эдж лимитед” компанийн хувьцааны бенефициар буюу ашиг хүртэгч өмчлөгч бол УИХ-ын гишүүн С.Батболд болохыг мэдүүлсэн байдаг. Энэ утгаараа Лондоны “Knightsbridge apartment” сууцуудын бенефициар өмчлөгч гэж тооцогдохоор байгаа. 2016 оны наймдугаар сарын 8-нд “Knightsbridge apartment3 сууцуудыг тухайн үед эзэмшсэн хэвээр буй УИХ-ын гишүүн С.Батболдын хүүхдүүд “Премиер эдж лимитед” компани дахь өөрсдийн хувьцааг БНСУ-

ын ирнэн Чёнг Чү Ёнгийн өмчлөлийн, Британийн Виржинийн арлуудад бүртгэлтэй “Лорш лимитед” хэмээх өөр нэгэн компанид худалдсан байна. “Лорш лимитед” гэх, оффшор бүсэд байгуулагдсан компани нь “Премиер эдж лимитед” оффшор бүс дэх компанийн 100 хувийн хувьцааг нэг сая фунт стерлингээр худалдан авсан нь тухайн үед “Премиер эдж лимитед” компанийн эзэмшиж байсан Лондон дахь өмч хөрөнгийн 15 сая ам.долларын үнэлгээний ойролцоогоор арван тавны нэг төдий болж байна уу даа. “Премиер эдж лимитед” компанийн хувьцаа “Лорш лимитед” рүү шилжсэн өдөр БНСУ-ын иргэн Чёнг “Премиер эдж лимитед” компанийн захирлаар томилогдож, улмаар дангаар хувьцаа эзэмшигч, захирал улмаар дангаар хувьцаа эзэмшигч, захирал болсон. 2017 оны арваннэгдүгээр сард, “Премиер эдж лимитед” компани Apartment 711 дүгээр сууцыг бусдад 1.85 сая фунт стерлинг буюу ойролцоогоор 2.5 сая ам.долларoор, өөрөөр хэлбэл, анх авахдаа төлсөн мөнгөнөөс хоёр дахин илүү үнээр худалдсан. 2018 оны наймдугаар сард захирал Чёнгийн хувьд Apartment 716 дугаар сууцыг өөрийн эзэмшлийн “Лорш лимитед” компанидаа шилжүүсэн. Гадаад зөвлөхүүдийн цуглуулсан эдгээр баримт, дүгнэлтээр бол УИХ-ын гишүүн С.Батболд дээрх этгээдүүдээр дамжуулан Лондонгийн “Knightsbridge apartment” сууцуудын эцсийн бенефициар өмчлөгч болох нь харагдаж байгаа юм. Энэ бол гадаадын шүүхийн мэдээллийн санд нээлттэй байгаа мэдээлэл тул та бүхэн холбогдох цахим хуудсаар нь нэвтэрч үзэж болно.

**Өөр ямар баримт бий вэ?**

**Хоёрдугаарт,** С.Батболд 2006 оны есдүгээр сарын 8-наас мөн оны арваннэгдүгээр сарын 1-нийг хүртэл буюу Монгол Улсын Их хурлын гишүүн байх хугацаандаа Британийн Виржинийн арлуудад 2006 оны долдугаар сарын 4-нд үүсгэн байгуулж бүртгүүлсэн “Винрок инвест лимитед” хэмээх оффшор компаниийн 100 хувийн хувьцаа эзэмшигч бөгөөд захирал байсан нь тогтоогдсон. Уг оффшор компанийн хувьцааг авах хүсэлт, мөн захирлаар ажиллах зөвшөөрлийн бичигт бүгдэд нь С.Батболд гишүүн өөрөө гарын үсэг зурсан байна. Тэгээд 2006 оны арваннэгдүгээр сарын 1-нд Монгол Улсад Авлигын эсрэг хууль дагаж мөрдөж эхэлсэн өдөр УИХ-ын гишүүн С.Батболд уг компанийн захирлаас чөлөөлөгдөж, БНСУ-ын иргэн Чёнг зэрэг төлөөний гэгдэх хүмүүс нь тогтмол ашигладаг “Cremunication limited” хэмээх компанид өөрийн хувьцааг нэр заан шилжүүлсэн. Хувьцаа шилжүүлэх баримтад мөн С.Батболд гэж өөрөө гарын үсэг зуржээ. Сү.Батболд “Winrock” компанийн хувьцааг эзэмших эрхээ хууль зүйн хувьд шилжүүлсэн хэдий ч 2006 оны арваннэгдүгээр сарын 1-нээс хойших хугацаанд тус компанийг удирдсаар байсан нь бусад холбоо хамаарлаар нь нотлогдож буйг гадаадын зөвлөхүүдийн цуглуулсан баримтуудаар тодорхойлохдоо “2006 оны 11 сарын 1-нээс хойш, “Винрок инвест лимитед” компани “Мүүнбэл групп лтд” хэмээх Британийн Виржинийн арлуудад бүртгэлтэй өөр нэгэн компанийн 100 хувийн хувьцаа эзэмшигч болсон, улмаар “Мүүнбэл групп лтд” компанийн захирлаар 2012 оны наймдугаар сард БНСУ-ын иргэн Чёнг томилогдсон. Тус компани нь УИХ-ын гишүүн С.Батболдын эзэмшлийн “Чингис хаан” зочид буудлыг бүртгэлтэй хаягаа болгон ашигладаг, Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж “Мүүнбэл” ХХК-ийг бүхэлд нь өмчилдөг байдлуудыг дурдсан баримт нийтэлсэн байгаа. 2008 оны наймдугаар сарын 31-нд “Moonbell group компанийн хаягийг “c/o Winrock Invest Ltd, 2/F Eton Tower, 8 Hysan Avenue, Causeway

Bay, Hong Kong” хаяг руу шилжүүлэн өөрчлүүлэх хүсэлтийг С.Батболд гэсэн гарын үсэг зурж үйлдэж байсан баримтыг шүүхийн журмаар гаргуулсан бөгөөд энэ нь тус компанийн үйл ажиллагааг УИХ-ын гишүүн С.Батболд удирдан чиглүүлж байсан нотлох баримт болж харагдаж байна. Ингээд урьдын адил, Монгол Улсад Авлигын эсрэг хуулийг дагаж мөрдөж эхэлснээр УИХ-ын гишүүн С.Батболд өөрийн мэдлийн хувьцааныхаа өмчлөлөөс татгалзаж, Солонгосын иргэн Чёнг “Винрок инвест лимитед” компанийн өмчлөгч болж, дараа дараагийн шилжүүлэлтүүд хийгдсэн асуудлыг лавшруулан тодруулах ажиллагааг гадаад улсын шүүхүүд үргэлжлүүлэн явуулж байна.

## С.БАТБОЛДЫН ЭСРЭГ НЭХЭМЖЛЭЛ ХУУЛИЙН ДАГУУ, ХЭНИЙ Ч ЗАХИАЛГААР ХИЙГДЭЭГҮЙ

**Бусдыг нь тодруулах боломжтой юу?**

**Гуравдугаарт,** “Женетрейд лимитед” болон “Грандкэстл ассетс инк” компанитай холбоотой баримтуудыг гадаад дахь шүүхийн ажиллагааны хүрээнд гаргуулахад УИХ-ын гишүүн С.Батболд, түүний хүү Б.Баттүшиг нар “Эрдэнэт үйлдвэр”-тэй ерөнхий сайд байх хугацаанд гэрээ байгуулсан Женетрейд Лимитед компанийн эцсийн бенефициар буюу ашиг хүртэгч өмчлөгч байсан нь харагдаж байгаа. 2006 оны есдүгээр сарын 8-нд Британийн Виржинийн арлуудад “Грандкэстл ассетс инк” нэртэй компанийг үүсгэн байгуулсан. УИХ-ын гишүүн С.Батболдын хүү Б.Баттүшиг 2007 оны нэгдүгээр сарын 22-ноос эхлэн “Грандкэстл ассетс инк” компанийн хувьцааг дангаар эзэмшиж, захирал байсан нь, “Грандкэстл ассетс инк” компанийн анхны захирлыг 2006 оны арванхоёрдугаар сарын 21-нд томилсон баримт, тус компанийн 2007 оны нэгдүгээр сарын 22-ны шийдвэр, Б.Баттүшигээс эл компанид хандан 2007 оны нэгдүгээр сарын 22-нд илгээсэн захидал зэрэг баримтууд бий. Холбогдох баримтуудын хувьд “Грандкэстл ассетс инк” компанийн Британийн Виржинийн арлууд дахь төлөөлөгчийн дотоод захидал харилцаанд УИХ-ын гишүүн С.Батболд, Б.Баттүшиг нарыг тус компанийн “Бенефициар өмчлөгч” хэмээн бүртгэсэн нь Фоена Сиугээс Самуэл Ходж, Лесиа Гразетте нарт 2009 оны гуравдугаар сарын 3-нд илгээсэн захидлаар батлагдаж байгаа. Сү.Батболдын хувь харилцагчийн менежер гэх иргэн Юан Вангаас УИХ-ын гишүүн С.Батболдын талаар сайшаан бичсэн захидал “Грандкэстл ассетс инк” компанийн бүртгэлийн баримт бичгүүдийн дотор агуулагдаж буй. Тус компанийн байгууллагын асуудал хариуцсан төлөөлөгч болох “Тридент траст” байгууллагаас “Грандкэстл ассетс инк” компанид хүргүүлсэн төлбөрийн нэхэмжлэх нь “c/o Winrock Invest Ltd, Room 19, 2/F,нэхэмжлэх нь “c/o Winrock Invest Ltd, Room 19, 2/F, Eton Tower, 8 Hysan Avenue, Causeway Bay, Hong Kong” хаягт хаяглагдсан. Business internet banking төлбөр хүлээн авсан баримтаас үзэхэд “Тридент траст” нь “Винрок инвест” компанийн төлбөрийн даалгавраар 350 ам.долларыг 2009 оны есдүгээр сарын 18-нд “Грандкэстл ассетс инк” компанитай холбогдох төлбөрт хүлээн авчээ. 2009 оны есдүгээр сарын 9-нд УИХ-ын гишүүн С.Батболдын хувь харилцагчийн менежер гэх Юан Ванг цахим шуудангийн захидал илгээхдээ “Грандкэстл ассетс инк” компанийн бенефициар өмчлөгч нь төлөөлөгч агент “Тридент траст компани лтд”-ийг өөрчлөн, “Нова сэйж инкорпорэйшнс лтд” компаниар солих хүсэлтэйгээ тайлбарласан байна. Солигдох болсон “Тридент траст” төлөөлөгч байгууллагын

ажилтнууд өөрсдийн дотоод захидал харилцаандаа, “хувийн байдлыг нь магадлан судлах талаар бидний тавьж буй шаардлагаас зайлсхийх зорилгоор тухайн үйлчлүүлэгч этгээд тус компанийн бүртгэгдсэн төлөөлөгч агент, бүртгэгдсэн хаягийг солихоор шийдсэн” гэсэн итгэл үнэмшилтэй байгаа тухайгаа тайлбарлан бичжээ. 2010 оны арваннэгдүгээр сарын сүүлчээр, Чёнг нь УИХ-ын гишүүн С.Батболдын тухайн үеийн хувь харилцагчийн банкны менежер Юан Вангтай зөвлөлдөж, зөвшөөрөл авсны үндсэн дээр Британийн Виржинийн арлуудад дээрх “Женетрейд” компанийг үүсгэн байгуулсан. Чёнг, Ванг нар мөн корпорац үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөгч Китти Чан нарын хооронд солилцсон хэд хэдэн цахим шуудангаас уг үйл явц тодорхой харагдана. “Грандкэстл ассетс инк” компани “Женетрейд”-ийн хувьцааг дангаар эзэмшигч болсон бөгөөд УИХ-ын гишүүн С.Батболдын төлөөний этгээд гэгдэх иргэн Канг Еун Жүүг захирлаар томилсон. Дараа нь 2010 оны арванхоёрдугаар сарын 24-ний үеэр иргэн Канг молибдений баяжмал худалдан авах гэрээ байгуулах боломжийн талаар ярилцахаар “Эрдэнэт үйлдвэр”-тэй холбогдсон. Уг оффшор бүс дэх компани 2010 оны арванхоёрдугаар сарын 24-нд мөн 2011 оны арванхоёрдугаар сарын 6-нд тус тус 7,000 тонн гаруй жинтэй молибдений нойтон баяжмал худалдан авах гэрээг “Эрдэнэт үйлдвэр”-тэй байгуулсан. “Эрдэнэт үйлдвэр” 68 сая ам.долларын өртгөөр 6,967 тонн нойтон баяжмалыг нийлүүлсэн байна.

**Дөрөвдүгээрт,** Монгол Улсын нутгийн зүүн хэсэгт байрлах 79.80 га талбайг хамарсан молибдений орд газрыг ашиглах тусгай зөвшөөрлийг “Билүүтмайнинг” ХХК хэмээх Монгол Улсад бүртгэлтэй компани эзэмшдэг. УИХ-ын гишүүн С.Батболд ашигт малтмал ашиглах энэ тусгай зөвшөөрлийг Британийн Виржинийн арлуудад бүртгэлтэй “Элмбридж ассетс лтд” гэх оффшор компаниар дамжуулан өөрийн нэрийн өмнөөс эзэмшүүлэхээр БНСУ-ын иргэн Чёнгийг нэр төдий этгээд болгон ашигласан гэх үндэслэлээр гадаад улсын шүүхүүдэд хандаад байгаа юм. Энэ компанийг 2009 оны долдугаар сарын 28-нд үүсгэн байгуулжээ. УИХ-ын гишүүн С.Батболдын нэр энэ компанийн захирлын бүртгэл, хувьцаа эзэмшигчийн бүртгэлд байгаагүй боловч, корпорац үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хадгалагдаж байсан баримтыг Британийн Виржинийн арлуудын шүүхийн захирамжаар гаргуулан авсныг уг цахим хуудас дахь баримт мэдээлэлд дурдагдаж байна. Компанийн баримт бичгүүд доторх байгууллагын бүтцээс харахад тус компанийг үүсгэн байгуулсны дараахан буюу С.Батболд гишүүнийг Гадаад харилцааны сайдаар ажиллаж байх үед “Элмбридж” компанийн цорын ганц “бенефициар өмчлөгч” хэмээн тодорхойлсон баримт байна. Уг компанийн “Suite 19, 2/F, Eton Tower” хаяг бол дээрх “Винрок инвест лимитед”, “Мүүнбэл групп” гэх компанийн ашигладаг хаягтай давхцаж байгааг харж болно. Энэ хаяг бол УИХ-ын гишүүн С.Батболд, түүний эхнэр, хүү Б.Баттүшиг нар Хонконг дахь HSBCPremier банкан дахь дансуудад мэдээлэл болгон гаргаж өгсөн хаягтай таарч буй нь тодорхой харагдана.

**УИХ-ын гишүүн Сү.Батболд эдгээр баримтыг няцаах боломж бий болов уу?**

Оффшор бүс, бусад гадаад улс дахь шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд цугларч ил болсон эдгээр баримтыг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нөгөө тал буюу хариуцагч УИХ-ын гишүүн С.Батболд үгүйсгэх, няцаах, үндэслэлгүй болохыг тогтоолгох бүрэн боломжтой. Энэ нь аль ч улсад явагдаж байгаа

иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ижил, тэгш олгогдсон боломж. Энэ боломжийг гадаад улсууд дахь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа шүүхүүд хугацаа заан олгосон, ажиллагаанууд үргэлжлэн явуулсаар байгаа. Өнөөдрийн байдлаар дээрх болон бусад баримтыг няцаасан, үндэслэл бүхий нотолгоо, тайлбарыг гадаад дахь шүүхүүдэд хариуцагч тал, түүний өмгөөлөгч нар гаргаагүй, хөрөнгө битүүмжлэх арга хэмжээг авсан шүүгчийн захирамжууд хүчинтэй хэвээр үйлчилж байгаа гэсэн мэдээлэлтэй байна. Эцэст нь хэлэхэд, Монгол Улс Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй орнуудад, тухайн улсын хуульчидтай хамтран явуулж эдгээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монгол Улсын үндэсний эрх ашигт нийцсэн, хуулийн үг хэллэгээр нь бол төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хийж буй, хууль бус замаар гадаад улсад гарсан хөрөнгийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа гэж ойлгох хэрэгтэй. Энэ нь аливаа улстөрч, эсхүл улс төрийн хүчний эсрэг бус, эсхүл хэн нэгний захиалгаар бус, АТГ-аас явуулж буй мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд тулгуурласан, хууль, Монгол Улсын нэгдэн орсон Авлигын эсрэг болон Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай хэрэгтэй тэмцэх НҮБ-ын конвенцын хүрээнд хийж буй хөрөнгө хамгаалахад чиглэсэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэдгийг онцлон тэмдэглэе.

Ярилцсан: "Өнөөдөр" сонины сэтгүүлч Г.Равжаа,

eguur.mn

---

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2787